

**Өлгий сумын ЗДТГ-ын 03-р сарын 29-с эхлэн 7 хоногт
хийсэн ажлын мэдээлэл**

2019-04-04

- Өлгий сумын 5-р багийн нутаг дэвсгэр “А” бүсэд байрлалтай нийт 50 гаруй байгууллага, аж ахуйн нэгжид орчноо тохижилт хийх талаар сумын Засаг даргаас албан бичиг хүргүүлэн хугацаатай үүрэг даалгавар өгөгдсөн болно.
- “Үндэсний үйлдвэрлэлийг дэмжье хариуцлагатай хэрэглээ” сэдэвт зохион байгуулагдсан аймгийн зөвлөгөөнд сумын хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах орон тооны бус зөвлөлийн гишүүд оролцсон болно.
- Тамхи худалдахаар тусгай зөвшөөрөл хүссэн 2 хүнсний дэлгүүрийн ЕБСургуулаас орших зайн хэмжээг тогтоож, схем зураглал үйлдэж баталгаажуулав.
- Аймгийн, сум орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хийгдэх бүтээн байгуулалтын ажлуудын газар сонголтыг хийж, техникийн нөхцөлийн зураглалыг гаргаж бэлтгэв.
- Иргэний танхимын дотор тасалгааны өөрчлөлт хийх зураглалыг үйлдэж, шинээр ШТС барих газрын сонголтыг хийж, сумын засаг даргад танилцуулан батлуулсан болно.
- Өлгий сумын Засаг даргад хүүхэд үрчлүүлэх талаар гаргасан 2 хүний өргөдлийн дагуу гэрт нь очиж дүгнэлт гаргаж, засаг даргын захирамжаар үрчлүүлэлт хийлгэв.
- Аймгийн төрийн албаны зөвлөлд Өлгий сумын ЗДТГазрын төрийн албан хаагч нарын зэрэг дэвийн судалгааг зохих маягтын дагуу гаргаж хүргүүлэв.
- Өлгий сумын 13 багийн иргэний нийтийн хурал амжилттай болж өндөрлөв, БИНХ-аас гарсан саналын маягыг эрэмбэлж, иргэдийн санал гомдлыг нэгтгэв.
- “Өлгий хотын орчны ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөлийг хангуулах” сарын аяны хүрээнд Мэргэжлийн хяналтын газартай хамт Өлгий сумын ХТАлбаны мэргэжилтэн, Багийн засаг дарга, байгаль хамгаалагч нар 04/147 тоот удирдамжийн дагуу аймгийн төвийн орон сууц, Ахдам, Тирлик зах, нийтийн зам, талбай, хогийн нэгдсэн цэг, халуун ус, зочид буудал, үсчин зэрэг үйлчилгээний байгууллагуудын Эрүүл ахуйн тухай хуульд заасан үүргийн хэрэгжилт, орчны цэвэрлэгээний чанар, хог зайлуулалтын байдлын талаар албан шаардлагын биелэлтэд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, ил задгай хог хаясан албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд албан шаардлага өгч арга хэмжээ авч ажилласан.
- Аймгийн 13 сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Нарийн бичгийн дарга нар Өлгий сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагаатай танилцаж харилцан туршлага судлан, өөр өөрсдийн туршлагаас хуваалцан уулзалт ярилцлага зохион байгуулан ажилласан болно.
- Аймгийн МХГазар, ХТАлба 12 багийн засаг дарга нартай хамт ариун цэврийн аяны ажлыг зохион байгуулан хяналт шалгалт хийв.
- МХГазар, Цагдаагийн газар, Өлгий сумын ЗДТГазраас зохион байгуулсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг сарын аяныг зохион байгуулж, хуваарийн дагуу 2 удаа эргүүл постонд гарч ард иргэдэд ухуулга сурталчилгаа хийж ажиллав.
- Онцгой байдлын газраас хөнгөлөлттэй үнээр олгосон 25 тн тэжээлийг аймгийн төвийн бүх багт хувиарлан өгч, малтай иргэдэд боломжийн хирээр олгов.
- Гудамж зам талбайн цэвэрлэгээ хийж 11 тн хог ачиж хогийн цэгт хүргэв.

- Гудамж зам талбайг шөнийн гэрэлтүүлгээр хангаж, төв талбайн гэрэлтүүлгийн урсгал засваруудыг хийж байна
- СӨХ-ны хогийг ачиж орон сууц орчмын цэвэрлэгээ хийж, хог шатаах явдалд хяналт тавьж ажиллаж байна
- Захиалгаар болон багийн засаг дарга нартай хамт нохой устгах ажил хийж 9ш нохой устгаж зайлуулав.
- Цэцэг тарих ажлын бэлтгэл ажлыг эхэлж цэцгийн мандлуудын шороог цэвэрлэж шарилжуудыг нь авч байна.

ӨЛГИЙ СУМЫН ЗДТГ